

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ЭРХЛЭХ АСУУДЛЫН ХҮРЭЭНИЙ ГАЗАР, ХЭЛТЭС,  
АГЕНТЛАГУУДЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНД ХИЙСЭН ХЯНАЛТ-  
ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

2023 оны 03 дүгээр сарын 20

Мандалговь хот

**НЭГ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ЗОРИЛГО**

Монгол улсын Засгийн газар болон аймгийн Засаг даргын Тамгын газраас боловсруулан баталсан бодлогын зорилтын хэрэгжилтийг зохицуулах, төрийн захиргааны болон нутгийн захиргааны удирдлагын манлайллыг хангах, чадавхыг сайжруулах, үйл ажиллагааны үр дүнг дээшлүүлэх сайн туршлагаа хуваалцах, харилцан суралцах, иргэд олон нийтийг мэдээллээр хангаж, цаашид анхаарах болон авч хэрэгжүүлэх арга хэмжээний чиглэлээр зөвлөгөө, удирдамжаар хангахад оршино.

**ХОЁР.ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ, АРГА ЗҮЙ**

Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, Захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”, Аймгийн Засаг даргын 2017 оны А/452 дугаар захирамжаар баталсан Сумдын Засаг дарга, Засаг даргын Тамгын газар, аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагуудын тухайн жилийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх журам”-ын дагуу Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар, хэлтэс, агентлагийн 2022 оны жилийн эцсийн үйл ажиллагааны үр дүнд хяналт-шинжилгээ үнэлгээ хийлээ.

Үйл ажиллагааны үр дүнг үнэлэхэд дараах баримт бичгүүдийг хамруулсан. Үүнд:

**1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:**

1.1.Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт

1.2.Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

1.3 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

**2. Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ болох:**

2.1.Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээ

2.2. Аймгийн Засаг даргаас агентлагийн дарга нартай байгуулсан үр дүнгийн гэрээний биелэлт

2.3.Төрийн албан хаагчийн сургалт, нийгмийн баталгааг хангах тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт

2.4.Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт

### 3. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ болох:

3.1 Байгууллагын ил тод байдлын үнэлгээ

3.2 Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээ


### 4. Хүний хөгжлийг дэмжих жил болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан 9 арга хэмжээ:

Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журмын 6.2, 6.3-т заасан арга зүйгээр дээрх 10 үзүүлэлтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийхдээ тухайн ирүүлсэн тайлангаас гадна холбогдох нэгж, байгууллагаас нэмэлт тодруулга авах, Тамгын газрын хэлтсүүдээс жилийн эцсийн үнэлгээг авч шууд хэрэглэх мөн нотлох баримт болон статистик мэдээлэлтэй харьцуулалт хийсэн болно.

## ГУРАВ. ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДҮН

### 1. Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ болох:


1.1 Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс Засгийн газрын хэрэг эрхлэх газраас ирүүлсэн сар бүрийн үнэлгээг харгалзан өгсөн.



**Дүгнэлт, зөвлөмжийн талаар:** Хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг сар бүр Засгийн газрын хэрэг эрхлэх газарт тайлагнадаг болсонтой холбогдуулан 2022 оны 8 сараас хойших сар бүрийн үнэлгээний дунджийг харгалзан жилийн эцсийн үнэлгээг тооцож гаргасан. Цаашид хууль, тогтоомж тогтоол шийдвэрүүдийг бүрэн хяналтад авч сар бүр тодорхой үр дүнтэй ажлуудыг зохион байгуулан тайланг, нотлох баримтын хамт тогтоосон хугацаанд чанартай ирүүлж байх шаардлагатай.

## 1.2 Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний биелэлт


Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн төлөвлөгөөний биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийж үнэлгээг өгсөн.



**Дүгнэлт, зөвлөмжийн талаар:** Зорилт, арга хэмжээний үйл явцыг биш, гүйцэтгэлийн үр дүнг тоо баримт, нотолгоотой тайлагнах хэрэгтэй. Цаашид тухайн төлөвлөсөн арга хэмжээ нь хүрэх түвшиндээ хүрсэн эсэх, хэрэгжсэнээр ямар үр дүнд хүрснийг тайлбарлаж нотолсон хэрэгжилтийг тооцож үнэлэхийг анхаарна уу.

## 1.3 Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлт

Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс үнэлгээг өгсөн.




**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг жилийн эцсийн байдлаар гаргуулан аймгийн статистик мэдээлэл болон салбарын

статистиктай тулган үнэлгээг журмын дагуу хийсэн. Эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийн тоон мэдээллийг статистикийн тоон мэдээлэлтэй тулган үзэхэд зарим үзүүлэлтийн тоон мэдээллүүд зөрүүтэй худал тайлагнаж байна. Цаашид аймгийн статистикт өгч байгаа тоон мэдээллийг салбарын тоон мэдээлэлтэй тулган үзүүлэлт бүрийн хувьд нотлох баримтын хамт тайлбартай үнэн зөвөөр тайлагнаж хэвших нь зүйтэй. Мөн эдийн засаг нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг салбарын статистик үзүүлэлтүүдтэй тулган шинэчлэх шаардлагатай.

Иймд байгууллагын удирдлагууд мэргэжилтэн албан хаагчдын судалгаа, тайлан мэдээнд хяналт тавьж, чанаржуулахад анхаарах нь зүйтэй.

## 2.1 Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээ

Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний үнэлгээг гаргахдаа тухайн агентлагт хамааралтай заалтын дундаж үнэлгээгээр гаргасан.



**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх арга хэмжээний дундаж 93.2 хувьтай хэрэгжүүлэн ажиллаж өмнөх онтой харьцуулахад 3.1 хувиар ахисан байна.


Гэрээний хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10а хавсралтын дагуу оны эхэнд Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолж, шалгуур үзүүлэлтийг оновчтой тодорхойлон, суурь түвшин, хүрэх түвшнийг бодитой тооцон төлөвлөж батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх шаардлагатай байна.

Хэрэгжилт удаашралтай байгаа болон тасарч болзошгүй арга хэмжээг эрчимжүүлэх ажлыг байгууллагын хэмжээнд зохион байгуулж удирдлагуудыг мэдээллээр хангах байх.

Тайлан мэдээний чанарт анхаарч оны эхнээс өөрийн агентлагт хамааралтай арга хэмжээ тус бүр дээр зарцуулсан хөрөнгийн хэмжээг зайлшгүй тайлагнаж байхаас гадна заалт тус бүрийн нотлох баримтыг оны эхнээс цуглуулж хагас, бүтэн жилээр нотлох баримттайгаар тайлан мэдээний хуваарийн дагуу тайлагнаж байх.

## 2.2 Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт

Байгууллагын тухайн жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг аймгийн Засаг даргатай байгуулсан гэрээний үүргийн биелэлтэд Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсээс хяналт шинжилгээ, үнэлгээ хийгдэж баталгаажсан үнэлгээг шууд хэрэглэсэн.




**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилт 93.4 хувьтай үнэлэгдсэн бөгөөд урд онтой харьцуулахад 1 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

Байгууллагын гүйцэтгэлийн 2022 оны төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээ хийж өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн үр дүнг гүйцэтгэлийн төлөвлөгөөний хагас жилийн хэрэгжилтийн хамт ирүүлэх

Мөн гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийн талаар улирал бүр байгууллага дээрээ хяналт шинжилгээ хийж, цаашид эрчимжүүлэх арга хэмжээ авч байхыг зөвлөж байна.

## 2.3 Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх тухайн жилийн төлөвлөгөөний хэрэгжилт

Төлөвлөгөөний биелэлтийг жилийн эцсийн байдлаар гаргуулан хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтсийн өгсөн үнэлгээгээр үнэлгээний дүнг гаргасан. Хяналт шинжилгээ, үнэлгээ хийхдээ төлөвлөлт, тайлагналтын чанарыг харгалзан хийсэн болно.




**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний хэрэгжилтийн дундаж 94.2 хувь урд онтой харьцуулахад 10 хувиар ахисан байна.

Дээрх төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 4 дүгээр хавсралтын шалгуур үзүүлэлтийн дагуу төлөвлөж, хэрэгжилтийг тоо баримт, үр дүн талаас хагас бүтэн жилээр тайлагнах

#### 2.4 Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлт

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийн биелэлтийг жилийн эцсийн тайлангуудад үндэслэн холбогдох хэлтсүүд үнэлгээг өгч үнэлгээний нэгдсэн дүнг гаргасан.



Д/д	Үндсэн үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийг дүгнэх үндэслэл	Үнэлэх аргачлал	Авбал зохих оноо	БОАЖГ	БТСГ	БШУГ	ГХБХБГ	ГБХЭХГ	МЭГ	НДХ	ОБГ	ОНӨГ	СУГ	СХ	СХДАА	СХЗХ	ТХ	УБХ	УЦУОШГ	ХХААГ	ХХҮГ	ЦГ	ШШГГ	ШШХ	ЭМГ	ЭМДХ
<b>Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс</b>																											
ХШҮ-ний зөвлөмж (2021он)	2021 үйл ажиллагааны үр дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	ХШҮХ-т зөвлөмжийн хэрэгжилтийг хугацаанд нь ирүүлсэн байдал	Хугацаандаа ирүүлсэн байдал	5	5	5	5	3	0	0	0	0	5		5	3	0	5	5	5	5	3	2	0		3	
	2021 үйл ажиллагааны үр дүнгээр өгсөн зөвлөмжийн хэрэгжилт	Зөвлөмжийн хэрэгжилтийн хувь	Хэрэгжилтийн хувиар тооцох	15	14.7	13.2	14.4	15	13.8	14	13.5	12.8	12		13.8	12.7	12.7	14.4	14.3	14.3	13.2	14.5	13.5	14.1		13.7	
Хэсгийн дүн				20	19.7	18.2	19.4	18	13.8	14	13.5	12.8	17		18.8	15.7	12.7	19.4	19.3	19.3	18.2	17.5	15.5	14.1	0	16.7	
<b>Хоёр.Төрийн захиргааны удирдлагын хэлтэс</b>																											
СӨГ-ын шийдвэрлэлт, цахим үйлчилгээ	Байгууллагын цахим шилжилт	Иргэдээс ирүүлсэн санал хүсэлт, өргөдөл гомдол шийдвэрлэлт	Өргөдөл, гомдлын бүртгэл /Цахим бүртгэл, гар бүртгэл тулгаж үзэх/	5	5	3	5	5	3	5	3	5	3	3	4	4	4	3	5	3	5	5	4	3	3	3	
			СӨГ-ын шийдвэрлэлт ийн хувиар -5 оноо (хувийг оноонд шилжүүлж тооцох)	5	5	4	5	5	3	5	3	3	3	3	4	4	4	4	4	4	4	5	4	4	4	3	4

		(нотлох баримттай тулган нягтлах)																								
	Ирсэн явсан бичгийн бүртгэл, шийдвэрлэлт	Явсан бичгийн бүртгэл (ERP бүртгэл, бүртгэлийн дэвтрийн бүртгэл тулгах)	5	5	3	5	5	3	3	2	2	3	3	3	3	4	5	4	4	3	3	5	5	4	4	
		Ирсэн бичгийн бүртгэл (ERP бүртгэл, бүртгэлийн дэвтрийн бүртгэл тулгах)	5	5	3	5	5	3	5	2	4	3	3	3	4	3.5	4	5	3	5	5	4	3	5	4	4
		Ирсэн бичгийн шийдвэрлэлт ийн тайлан (Цахим)	5	5	5	5	5	2.5	5	5	5	5	5	4	4	4	5	5	5	5	5	5	4	5	5	4
	Фэйж хуудас	Фэйж хуудастай бол (үгүй-0)	5	5	5	5	5	5	5	5	4	5	5	4	3.5	5	5	5	5	5	5	4	3	5	5	
		Фэйж хуудсаар дамжуулсан мэдээ, Фэйж хуудасны дагагч	5	5	5	5	5	4	5	5	4	5	5	4	5	5	5	5	3	5	5	5	5	5	5	
		Сайтын мэдээ, мэдээлэл (Мэдээллийн технологийн асуудал хариуцсан мэргэжилтний өгсөн үнэлгээгээр)	5	5	3	5	5	5	2	2	5	5		5	4	5	5	5	5	3	5	5	2	4	5	
	ERP ашиглалт	ERP цаг бүртгэл (албан хаагчдын ирцийн	5	5	3	2	5	1	3	2	5	4	3	3	5	2.5	3	3	3	4	5		5	5	5	5



		бүртгэл)																									
		Хүний нөөц (албан хаагчдын шилжилт хөдөлгөөн, албаны майл хаяг)	5	2	4	4	5	5	5	2	2	4	5	5	4	4	5	5	5	5	5	4	5	5	5		
Хэсгийн дүн			50	47	38	46	50	35.5	42	31	41	38	36	41	40	38.5	43	47	42	44	47	35	39	43	45	32	
<b>Гурав. Хууль, эрх зүйн хэлтэс</b>																											
Хууль, эрх зүй	Хууль, эрх зүйн архив, албан хэрэг хөтлөлт	Эрх зүйн актын боловсруулалт	Эрх бүхий албан тушаалтнууда ас батлагдаж буй захирамж, тушаал шийдвэрийн үндэслэлийг зөв сонгож, сумын Засаг даргын захирамж, шийдвэрийг батлагдсан хуваарийн дагуу Хууль, эрх зүйн хэлтсээр хянуулж, зөвлөмжийг хэрэгжүүлсэн эсэх	5	5	3	4	5	4	0	4	4	4	3	5	4	4	4	5	5	4	5	4	5	4	5	4
			Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийг мэдээ, мэдээллээр хангах	Тайлан, мэдээг хугацаандаа ирүүлсэн байдал	5	4	4	3	4	2	0	3	0	4	0	3	4	2	3	3	5	4	3	4	3	4	3

		Авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх хууль тогтоомжийн хэрэгжилт	Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөлт, биелэлт /Хугацаандаа чанартай тайлан ирүүлсэн байдал	5	2.5	0	2.5	2.5	5	2.5	2.5	2.5	0	0	5	0	5	5	5	2.5	5	5	2.5	0	0	2.5	0
		Архивын баримтын тоо бүртгэл /5 оноо/	Авлигын эсрэг Олон улсын өдрийг угтан зохион байгуулсан ажлын тайлан, мэдээ ирүүлэлт	5	5	5	5	5	5	2	2	3	3	5	3	3	2	2.5	5	5	3	4	0	0	0	3	0
			Баримтын бүрэлдэхүүн, тоо хэмжээний тайлагнасан байдал	5	5	0	0	5	5	0	0	0	0	0	0	0	0	3	0	0	0	5	0	0	0	5	0
Хэсгийн дүн				25	21.5	12	14.5	22	21	4.5	11.5	9.5	11	8	16	11	13	17.5	18	17.5	16	22	10.5	8	8	18.5	4
<b>Тав. Нийгмийн бодлогын хэлтэс</b>																											
Нийгмийн хүрээ	Нийгмийн хүрээ	Дундговь аймаг байгуулагдсаны түүхт 80 жилийн ойн баяр наадмын нээлтийн арга хэмжээнд оролцсон идэвх оролцоо	Баяр наадмын нээлтэд оролцох албан хаагчдын жагсаалтад орсон албан хаагчдыг 100 хувь оролцуулсан байдал	0	0	0	2	0	2				0	5		2	2	2	2	3		5		0	0	0	0

Ойн хүрээнд зохион байгуулсан Албан байгууллага, аж ахуйн нэгжүүдийн урлагийн үзлэгт оролцсон идэвх оролцоо	Урлагийн үзлэгт бэлтгэн оролцсон байдал	5	5	5	5	5	5	0	0	0	0	5	0	0	5	5	0	5	0	5	0	0	0	0	0	
Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийг дээшлүүлэх чиглэлээр зохион байгуулсан ажил, түүний үр дүн	Байгууллагын нийт албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийг ахиулсан ажил зохион байгуулсан байдал	5	0	4.8	5	5	5	0	5	0	5	0	0	0	0	5	5	5	0	0	5	0	0	5	0	
Байгууллагын дэргэдэх Эцэг, эхийн зөвлөлийн үйл ажиллагааны төлөвлөгөө, түүний хэрэгжилт	Төлөвлөгөөний гүйцэтгэлийн хувийг оноонд шилжүүлнэ.	5	4.5	4.6	5	0	5	0	0	5	0	0	5	0	0	5	5	5	5	5	5	5	4.8	0	5	0
<b>Хэсгийн дүн</b>		15	9.5	14.4	17	10	17	0	5	5	5	10	5	2	7	17	12	18	5	15	10	4.8	0	10	0	
<b>Нэгтгэсэн дүн</b>		110	97.7	82.6	96.9	100	87.3	60.5	61	68.3	71	54	80.8	68.7	71.2	96.9	96.3	96.8	83.2	102	71	65.9	51	90.2	36	
<b>Хувь</b>		100	88.8	71.8	84.3	86.5	75.9	55.0	55.4	59.4	65	57	73.5	59.7	61.9	84.2	83.7	84.7	72.3	88.2	71	57.3	44	78.4	45	


**Дүгнэлт, зөвлөмжийн талаар:** 2022 онд хяналт-шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн явцад хяналт шинжилгээ хийж цаашид анхаарах асуудал дээр зөвлөмж өгч ажилласнаар үнэлгээний дүн ахисан байна. Шүүхийн шинжилгээний хэлтэс өгсөн зөвлөмжийг хэрэгжилтийн тайлангаа ирүүлээгүй байна.

Цаашид Хяналт шинжилгээ үнэлгээний хэлтэс болон хяналт шинжилгээ, үнэлгээний багаас өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх талаар санал санаачлага гарган ажиллах шаардлагатай байна. Өмнө нь өгсөн зөвлөмжийг дахин давтан гаргахгүй байх талаар удирдлага арга зүйгээр ханган хяналт тавьж ажиллахыг агентлагийн удирдлагууд анхаарах хэрэгтэй байна.

Үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтийг холбогдох албан хаагчдад хариуцуулан хагас бүтэн жилээр хяналт тавьж ажиллах шаардлагатай.

### Гурав. Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ


3.1.Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг 46 шалгуур үзүүлэлтийн дагуу аймгийн сайтын төрийн байгууллагууд хэсэгт агентлаг бүрийн байршуулсан мэдээлэлд үндэслэн ТЗУХ-ээс үнэлгээг өгсөн.



**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Мэдээллийн ил тод, нээлттэй байдлын үнэлгээг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 9 дүгээр хавсралтын дагуу 46 шалгуур үзүүлэлтийн дагуу үнэлгээг Төрийн захиргааны удирдлагын хэлтсээс үзэж үнэлгээний дүнг гаргахад 56.4 хувьтай байгаа нь хангалтгүй байгаа тул Төрийн захиргааны удирдлагын хэлтэс болон агентлагууд онцгойлон анхаарч, дээрх шалгуур үзүүлэлтийн дагуу тухай бүр мэдээллийг үнэн зөв, цаг хугацаанд тогтмол оруулж хэвших

Агентлаг бүр уг шалгуур үзүүлэлтүүдийг холбогдох албан хаагчдад хариуцуулан хагас бүтэн жилээр хяналт тавьж байх.


3.2.Төсөв, санхүүгийн үйл ажиллагааны үнэлгээг Санхүү, төрийн сангийн хэлтсээс өгсөн үнэлгээг шууд хэрэглэсэн.



**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Шилэн дансанд мэдээллийг 5 агентлаг 100 хувь хуулийн хугацаанд бүрэн байршуулсан бол 2 агентлаг 90-ээс доош хувьтай байна. Иймд мэдээллийг хуулийн хугацаанд байршуулан агентлагийн дарга нар тогтмол хяналт тавьж ажиллах нь зүйтэй.

#### 4.Аймгийн тухайн жилийн зорилт, тусгайлан тусгасан заалтын хэрэгжилтийн үнэлгээ

4.1 2022 оны аймгийн дэвшүүлсэн зорилтын хүрээнд хэрэгжүүлсэн ажлын тайлан, Байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд аймгаас тусгайлан тусгасан 9 заалтын биелэлтийн тайланг сонсож ажлын хэсгээс үнэлгээ өгч үнэлгээний дүнг гаргасан.



**Дүгнэлт зөвлөмжийн талаар:** Хүний хөгжлийг дэмжих жил болон байгууллагын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан арга хэмжээний хэрэгжилтийн тайланг тавиулж ажлын хэсгийн гишүүн тус бүр дээрх 2 асуудлын хүрээнд хийсэн ажил, илтгэл бэлтгэсэн байдал, илтгэх ур чадвар гэсэн шалгуур үзүүлэлтээр үнэлгээг өгч ажлын хэсгийн гишүүдийн дундаж үнэлгээгээр үнэлгээний дүнг гаргасан.

Аймгаас дэвшүүлсэн зорилтын хүрээнд хийх арга хэмжээг тусгай төлөвлөгөө боловсруулан хэрэгжилт үр дүнгийн талаарх тайлан мэдээг тухайн зорилтыг хариуцан зохион байгуулах хэлтэст нотлох баримтын хамтаар тайлан мэдээний хуваарийн дагуу тайлагнаж байх

### **ДӨРӨВ. НЭГДСЭН ҮНЭЛГЭЭ, ДҮГНЭЛТ, ЗӨВЛӨМЖ**

Аймгийн Засаг даргын эрхлэх асуудлын хүрээний газар хэлтэс, агентлагийн 2022 оны үйл ажиллагааны үр дүнг 10 үзүүлэлтээр үнэлж дүгнэн үнэлгээний дүнг Засаг даргын зөвлөлийн хуралд танилцуулан аймгийн Засаг даргын 2023 оны А/140 дугаар захирамжаар үнэлгээний дүнг баталгаажуулж цаашид анхаарах асуудалд 10 заалт бүхий нийтлэг зөвлөмжийг гаргасан.

Үнэлгээний дүнг үзүүлэлт тус бүрээр хүснэгтээр харуулбал:

№	Үзүүлэлтийн нэр	100 хувь	90-99 хувь	80-89 хувь	79-оос доош хувь
1	Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ	3	12	4	4
2	Байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ	-	7	13	3
3	Байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ	-	2	10	11
4	Хүний хөгжлийг дэмжих жил, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан оруулсан арга хэмжээ	-	1	11	11

Үйл ажиллагааны үр дүнгийн үнэлгээний дундаж 83 хувь, урд онтой харьцуулахад 8.3 хувиар буурсан нь хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилтийн үнэлгээг Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас сар бүр өгсөн үнэлгээний дундаж хувиар, мөн ил тод байдлын үзүүлэлтийг урд онд 14 үзүүлэлтээр үнэлж байсан бол Засгийн газрын 2021 оны 374 дугаар тогтоолоор батлагдсан журмын 9 дүгээр хавсралтаар батлагдсан 46 шалгуур үзүүлэлтээр, шинээр нэмж дэвшүүлсэн зорилт болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгагдсан арга хэмжээний үнэлгээ зэргээр үнэлсэн учир үнэлгээний дүн буурсан байна гэж үзэж байна.

Бодлогын баримт бичгийн хэрэгжилтийн үнэлгээ 90.6 хувь, байгууллагын чиг үүргийн үзүүлэлтийн үнэлгээ 86.5 хувь, байгууллагын нээлттэй байдлын үнэлгээ 76.2 хувь, хүний хөгжлийн дэмжих жил болон байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан арга хэмжээний үнэлгээ 78.9 хувьтай байна. Үнэлгээний дүнгээр Ус цаг уур

орчны шинжилгээний газар тэргүүн байр, Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар Дэд байр, Байгаль орчин, аялал жуулчлалын газар Гутгаар байр эзэлсэн бол Стандарт хэмжилзүйн хэлтэс, Мал эмнэлгийн газар, Нийгмийн даатгалын хэлтэс, Соёл урлагийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Шүүхийн шинжилгээний алба зэрэг 6 агентлаг дутагдалтай үнэлэгдсэн байна.

Үйл ажиллагааны үзүүлэлтүүдээс хууль тогтоол шийдвэрийн хэрэгжилт 77.5 хувь, мэдээллийн ил тод нээлттэй байдлын үнэлгээ 56.4 хувь, Хүний хөгжлийг дэмжих жил, байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусгайлан тусгасан арга хэмжээ 78.9 хувьтай байгаа тул агентлагууд онцгойлон анхаарч үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтийг ахиулж ажиллах нь зүйтэй.

## ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ХЭЛТЭС

БАТЛАВ  
 .....АГЕНТЛАГИЙН ДАРГА / НЭР/  
 2023 оны.... сарын.....

.....БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН НИЙТЛЭГ  
 ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨЛӨВЛӨГӨӨ

2023 оны.....сарын.....

Мандалговь хот

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжүүлэх хугацаа	Хариуцах албан тушаалтан
1	2	3	4	5	6	7	8
1	Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 5 сарын 1-ний дотор багтаан бүрэн байршуулах.		ЗГХЭГ-ЫН ДАРГЫН 100 ТУШААЛЫГ УНШИЖ ТОДОРХОЙЛОХ				
2	Сар бүрийн эхний 10 хоногийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эрчимжүүлэх өдөр болгон үр дүнтэй ажил зохион байгуулж, хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх.						
3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг шинэчлэн батлуулж, үзүүлэлтийн үр дүнг сум бүрээр гарган эмхэтгэл хийж иргэдэд мэдээлэх.						
4	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хавсралтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10а хавсралтын дагуу төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолон батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх.						
5	Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн						



	захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх.						
6	Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах						
7	Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх						
8	Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах						
9	Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.						
10	Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлан хэрэгжилтийн тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй хамт нотлох баримттайгаар тайлагнаж байх						

ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛСАН  
.....АЖИЛТАЙ .....

.....БАЙГУУЛЛАГЫН 2022 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮНГ ҮНЭЛЖ ӨГСӨН ЗӨВЛӨМЖИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ  
ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ХЭРЭГЖИЛТ

№	Өгсөн зөвлөмж	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
1	2	3	4	5	6	7	8
1	Засгийн газрын 374 дүгээр тогтоолоор батлагдсан шалгуур үзүүлэлтийн дагуу мэдээллийг аймгийн сайтад 5 сарын 1-ний дотор багтаан бүрэн байршуулах.						
2	Сар бүрийн эхний 10 хоногийг хууль тогтоомж, тогтоол шийдвэрийг эрчимжүүлэх өдөр болгон үр дүнтэй ажил зохион байгуулж, хэрэгжилтийн хувийг нэмэгдүүлэх.						
3	Эдийн засаг, нийгмийн хөгжлийн үзүүлэлтийг шинэчлэн батлуулж, үзүүлэлтийн үр дүнг сум бүрээр гарган эмхэтгэл хийж иргэдэд мэдээлэх.						
4	Засгийн газрын зарим чиг үүргийг орон нутагт төлөөлөн хэрэгжүүлэх гэрээний хавсралтаар хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Засгийн газрын 2021 оны 374 дүгээр тогтоолоор батлагдсан журмын 10а хавсралтын дагуу төлөвлөлтийн шаардлагыг ханган томьёолон батлуулах, хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж байх.						
5	Цахим албан бичгийн дотоод үйл ажиллагааны цахимжуулалт, цахим албан хэрэг хөтлөлтийн тайланд улирал бүр дүгнэлт хийж, тайланг улирал бүрийн сүүлийн сарын 25-ны дотор Төрийн захиргааны удирдлагын хэлтэст цахимаар ирүүлэх.						
6	Цахим хуудасны мэдээ мэдээллийг тогтмол шинэчилж, аймаг орон нутгийн мэдээллийг өөрийн албан ёсны фэйсбүүк хуудсаараа дамжуулан нийтэд түгээх, фэйж хуудасны хандалтын тоог нэмэгдүүлэх талаар тогтмол анхаарч үр дүнг сар бүр тооцон ажиллах						

7	Байгууллагын дотоод удирдлагын ERP системийн ашиглалтыг сайжруулж, цаг бүртгэл, үүрэг даалгаврын цахим системд шилжиж, нийт албан хаагчдын цахим ур чадвар, тоон боловсролыг дээшлүүлэх						
8	Шилэн дансанд мэдээлэл оруулсан байдалд улирал бүр хяналт тавьж, хуулийн хэрэгжилтийг 100 хувь хангах						
9	Байгууллагын албан хаагчдын монгол бичгийн мэдлэгийн түвшнийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж, явцын тайланг Нийгмийн бодлогын хэлтэст 6, 11 сарын 10-ны дотор тайлагнах.						
10	Төрийн албаны тухай хуулийн 55.3-ын дагуу байгууллага бүр төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл нийгмийн баталгааг хангах хөтөлбөрийг боловсруулан баталж, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хавсралтаар батлан хэрэгжилтийн тайланг байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилттэй хамт нотлох баримттайгаар тайлагнаж байх						
11	Хэрэгжилтийн дундаж хувь						

ХЭРЭГЖИЛТИЙН ХЯНАСАН

.....ДАРГА .....

ХЭРЭГЖИЛТ ТООЦСОН

.....МЭРГЭЖИЛТЭН.....